

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс/

2024 он



СҮХБААТАР АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭСТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨХИРҮУЛАГЧ АГЕНТЛАГ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Энхтайваны өргөн чөлөө 46а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13343
Утас: 45 83 49, Факс: (976-11) 45 80 32,
Цахим шуудан: info@masm.gov.mn,
Цахим хуудас: www.masm.gov.mn

2024 06 27 № 01/648
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/152 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг танай хэлтсийн үйл ажиллагаанд 2024 оны 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд хяналт-шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд ажил сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Дүгнэлт, зөвлөмжтэй танилцан хэрэгжилт хангалтгүй буюу дутуу хэрэгжилттэй арга хэмжээг эрчимжүүлэх, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх талаар гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 2024 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, хэрэгжилт, үр дүнгийн тайланг Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журамд заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэн ажиллана уу.

Хавсралт 12 хуудастай.

ДАРГА



С.БАТБААТАР

132215801

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн нэгж:

Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс

Хугацаа: 2024 оны 06 дугаар сарын 13-14-ний өдөр

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:	Ч.Отгонцэцэг	(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Х.Отгонбазаррагчаа	(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн)
	Ж.Мөнхбаяр	(Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн)
	М.Буянжаргал	(Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн мэргэжилтэн)

Хяналт-шинжилгээ хийсэн чиглэл:

1. Стандарт, хэмжил зүйн газрын даргатай байгуулсан Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх;
2. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, албан хаагчдын ажлын ачаалал, байгууллагаас гаргасан тушаал шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;
3. Хуулиар олгогдсон чиг үүргийн хэрэгжилттэй танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт;
 - Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга;
 - Хэмжил зүйн хяналт шалгалт;
 - Сорьцын хяналт;
 - Сорилтын лабораторийн үйл ажиллагаа;
 - Стандартын салбар сангийн үйлчилгээ;
4. Хэлтсийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, захиран зарцуулалт, орлогын гүйцэтгэл, төвлөрүүлэлт, гэрчилгээ тооцоот баримт бичгийн ашиглалт, шилэн дансны мэдээлэлд хяналт хийх, санхүүгийн сахилга бат хэрхэн хангагдаж буйд үнэлэлт дүгнэлт өгөх;
5. Стандарт хэмжил зүйн салбарын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавих шаардлага CS-11-0182:2022 байгууллагын стандартын хэрэгжилтийг үнэлэх;
6. Байгууллагын архив, албан хэргийн хөтлөлтийн үйл ажиллагаа, бүртгэгдсэн өргөдөл, гомдол, түүний барагдуулалтад үнэлэлт дүгнэлт өгөх;
7. Ил тод байдал, нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;
8. Өмнөх хяналт-шинжилгээнээс өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
9. Стандарт, хэмжил зүйн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас өгсөн шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
10. Бусад;

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭСТ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж, 2024 оны Стандарт, хэмжил зүйн газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө болон өмнөх хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн дутуу гүйцэтгэлтэй ажлуудыг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, ажилтан, албан хаагчдын сахилга, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үнэлэлт дүгнэлт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Аргачлал: Үйл ажиллагааны зохион байгуулалтын талаар хэлтсийн удирдлага болон албан хаагчтай ярилцах, саналыг сонсох, түүнчлэн баримт бичигт дүн шинжилгээ хийхдээ түүвэрлэн сонгох аргуудыг ашигласан.

Нээлтийн хурал: Агентлагийн даргын баталсан удирдамжийн хүрээнд 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Сүхбаатар аймаг дахь СХЗХ-ийн ажилтан, албан хаагчдыг байлцуулан нээлтийн хурлыг хийж, ажлын хэсгийн ахлагч бөгөөд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Отгонцэцэг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/152 дугаар тушаалаар батлагдсан Хяналт-шинжилгээ хийх удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 2023 онд аймаг дахь СХЗХ-ийн үйл ажиллагаанд хийсэн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, нийтлэг илэрсэн алдаа дутагдал, анхаарах асуудал, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар товч мэдээлэл хийсэн.

Хаалтын хурал: 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдөр Хэлтсийн дарга М.Чинзориг, Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд ахлах мэргэжилтэн Ц.Өлзийжаргал, Сургалт мэдээлэл, стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхжаргал, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн Э.Цогдэлгэр, Д.Зоригтбаатар, Нягтлан бодогч О.Эрдэнэцэцэг, Лабораторийн эрхлэгч Н.Цолмонтуяа, шинжээч Б.Эрдэмбилэг, Батаагийн Мөнхцэцэг, Батсүхийн Мөнхцэцэг, архив, бичиг хэрэг Ч.Соёлцэцэг, Хэмжүүр баталгаажуулалтын техникч А.Нямдулам, Лаборант Г.Саруулцэцэг нарыг байлцуулан хяналт-шинжилгээний үр дүн, хяналт шинжилгээний мөрөөр гүйцэтгэл сайжруулах зөвлөмжийг танилцуулж, хэлтсийн тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл солилцлоо.

НЭГ. СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦАХ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГӨХ;

Тус хэлтэс нь Стандарт хэмжил зүйн газрын даргатай байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Хэрэгжилтийн түвшинд үнэлгээ хийж доорх арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллах нь зүйтэй гэж дүгнэсэн. Үүнд:

№	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ
0	1	2
1.	1.2	Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулгын үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэх;
2.	3.3	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт санал боловсруулж, тусгуулах;
3.	4.2	Аймгийн хэмжээнд ашиглагдаж буй хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийх; - Цахилгаан;

4.	4.5	2023 оны гэрээний хэрэгжилтийг дүгнэх, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулах; - Гэрээнд нэгдсэн дугаарлалт олгох.
5.	4.6	Аймгийн хэмжээнд хэмжил зүйн хяналт-шалгалтад хамрагдах хэмжих хэрэгслийн судалгааг хэмжлийн төрөл тус бүрээр гаргаж мэдээллийн сан бий болгох; (Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан "Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалт")
6.	5.1	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах;
7.	5.2	Төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах;
8.	6.1	Бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээжүүлэх;
9.	6.3	Засгийн газрын 291 дүгээр тогтоолоор баталсан заавал баталгаажуулалтад хамруулах бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх; ✓ Бүтээгдэхүүн ✓ үйлчилгээ
10.	6.4	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүд, хүнсний үйлдвэрүүдэд ISO 9001, ISO 22000 стандарт, НАССР тогтолцоо, зохистой дадал нэвтрүүлэх, органик бүтээгдэхүүнийг баталгаажуулалтад хамруулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
11.	6.5	ISO/IEC 17065 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэж, итгэмжлэгдэх;
12.	6.6	Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн салбар сангаар үйлчилгээ үзүүлж стандартаар хангах;
13.	9.3	ISO 9001 стандартын хэрэгжилтэд дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээг зохион байгуулж, байнгын сайжруулалт хийн ажиллах;

ХОЁР ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН АЧААЛАЛ, БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ТУШААЛ ШИЙДВЭР НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН БАЙДАЛД ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ;

2.1 Албан хаагчдын ажлын ачаалал

Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь нийт 15 албан хаагчтай үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс:

- Төрийн захиргааны албан хаагч -5 (Хэлтсийн дарга -1, сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд ахлах мэргэжилтэн -1, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн-2, стандартын салбар сангийн мэргэжилтэн-1)
- Төрийн үйлчилгээний албан хаагч: 10 (нягтлан бодогч -1, лабораторийн эрхлэгч-1, таримал ургамал, үр хорио цээрийн шинжээч-1, нян судлалын шинжээч-1, хими хор судлалын шинжээч-1, архив, бичиг хэргийн ажилтан-1, техникч-1, лаборант-1, жолооч-1, үйлчлэгч -1)

Ажлын ачааллын хувьд:

№	Нэр	Албан тушаал	Хяналт шалгалт, олгосон гэрчилгээ болон борлуулсан стандартын тоо		
			Үзүүлэлтүүд	2023	2024.06
1	2	3	4	5	6
1.	Ц.Өлзийжаргал	Сорьцын хяналтын улсын байцаагч	Объектын тоо	5	4

		Бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн	Бүтээгдэхүүн Үйлчилгээ Экспортын гэрчилгээ	3 64 46	0 116 45
2.	Э.Цогдэлгэр	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн	Масс	588	396
			Эзлэхүүн	346	525
3.	Д.Зоригтбаатар		Шалгалт тохируулга (масс)	27	22
			Даралт	163	156
			Цахилгаан	2506	61
4.	Б.Мөнхжаргал	Стандартын салбар сан, сургалт хариуцсан мэргэжилтэн	Борлуулсан стандартын тоо	274	37
			Сургалтын тоо/ хамрагдсан хүний тоо	2/25	40/994
			Зөвлөгөө өгсөн байгууллагын стандартын тоо	0	3
5.	Н.Цолмонтаяа	Микробиологич	Сорьцын тоо	317	133
			Үзүүлэлтийн тоо	670	245
6.	Б.Эрдэмбилэг	Химич	Сорьцын тоо	294	167
			Үзүүлэлтийн тоо	1030	615
7.	Б.Мөнхцэцэг	Таримал ургамлын үр хорио цээрийн шинжээч	Сорьцын тоо	43	2
			Үзүүлэлтийн тоо	43	2

Албан хаагчдын хувийн хэргийг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу бүрдүүлсэн байна.

Зарим тушаалын эрх зүйн үндэслэл буруу, утга найруулга, зөв бичих дүрмийн алдаатай байна.

Хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн орон тоо буюу сүүлийн 2 жил хэмжил зүйн хяналт шалгалт хийгдээгүй байна.

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОГДСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ТАНИЛЦАХ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГӨХ;

3.1 Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтын чиглэлээр:

Сүхбаатар аймгийн СХЗХ-ийн Баталгаажуулалтын алба нь Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2020 оны А/40 дугаар тушаалаар 13 ангиллын 68 төрлийн бүтээгдэхүүн, 19 төрлийн үйлчилгээнд баталгаажуулалт гүйцэтгэхээр 4 жилийн хугацаагаар итгэмжлэгдсэн бөгөөд итгэмжлэлийн хугацаа дууссан.

Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд ахлах мэргэжилтэн Ц.Өлзийжаргал нь бүтээгдэхүүний баталгаажуулалтын мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэж байна.

Хэлтсийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Баталгаажуулалтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилсэн ба ахлах мэргэжилтэн нь бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлыг давхар гүйцэтгэж байхад зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж, мөн нарийн бичгийн даргаар томилжээ. Энэ нь СХЗГ-ын даргын 2021 оны А/132 дугаар тушаалаар батлагдсан Баталгаажуулалтын зөвлөлийн дүрмийн 1.3 –т заасан зарчим, Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17065 стандартын 7.6.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Тус зөвлөл нь 2023 онд 6 удаа хуралдаж 64 үйлчилгээ, 24 бүтээгдэхүүнд, 2024 оны 06 дугаар сарын байдлаар 4 удаа хуралдаж, 114 үйлчилгээнд Тохирлын гэрчилгээ олгох шийдвэр гаргажээ.

Тохирлын гэрчилгээг хэвлэхдээ e-certification программ ашиглаж байна.

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтын үйл явцад Тохирлын гэрчилгээ олгосон бүртгэлээс түүвэр байдлаар авч баримтжуулсан мэдээлэлд дүн шинжилгээ, хяналт шинжилгээ хийн ажиллалаа.

Сайжруулалтын зөвлөмж:

1. Аж ахуйн нэгж, иргэдээс Тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн хүсэлтийг ирсэн баримт бичгийн бүртгэлийн дэвтэрт бүрэн бүртгэх, дарга нь тухай бүр цохолт хийх;
2. Хүсэлт гаргагчтай холбоо тогтоосон тэмдэглэл хөтлөх;
3. Хурлаар хэлэлцүүлсэн тайланд асуудлыг бүрэн тусгах;
4. Хурлын тэмдэглэлийн хөтлөлтийг сайжруулах;
5. Баталгаажуулалтын зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилох, идэвх оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
6. Шударга байдлын хороо байгуулах;
7. Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17065 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэх, итгэмжлэгдэх;

3.2 Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын чиглэлээр:

Хэмжил зүйн нэгж дамжуулалт:

Сүхбаатар аймаг дахь СХЗХ-ийн хэмжил зүйн лаборатори нь 16 ширхэг ажлын эталон тоног төхөөрөмжийн бүртгэлтэй ба 2024 онд дараах ажлын эталонуудыг шалгалт тохируулгад хамруулан нэгж дамжуулалтыг ханган үйл ажиллагаандаа ашиглаж байна.

1. Массын хэмжлийн нийт 10 ширхэг ажлын эталонгоос:
 - 2022 онд 2 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан;
 - 2023 онд 5 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан;
 - 2024 онд 3 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан.
2. Эзлэхүүн зарцуулалтын хэмжлийн нийт 3 ширхэг ажлын эталонгоос:
 - 2023 онд 2 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан;
3. Даралтын хэмжлийн 1 ширхэг ажлын эталонгоос:
 - 2024 онд 1 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан.
4. Цахилгаан хэмжлийн нийт 1 ширхэг ажлын эталонгоос:
 - 2024 онд 1 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан.

Хүний нөөцийн мэдээлэл:

- Э.Цогдэлгэр (масс, эзлэхүүн зарцуулалт)-ын цахилгааны хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн давхар эрхтэй. Нэмэлтээр (масс, эзлэхүүн)-ний хэмжлийн төрлөөр шалгалт тохируулгын давхар эрхтэй.
- Д.Зоригтбаатар (цахилгаан, даралт)-ын хэмжлийн төрлөөр улсын шалгагчийн давхар эрхтэй;
- А.Нямдулам хэмжүүрийн техникчээр ажилладаг.

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн-2, техникч-1, нийт 3 хүний орон тоотойгоор хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Тоо, орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлт:

2024 онд 9 аж ахуйн нэгж, байгууллагатай хэмжих хэрэгсэлд ээлжит шалгалт баталгаажуулалт хийх гэрээг байгуулан ажиллаж байна. 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 1122 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, 22 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж, нийт 17,582,000 төгрөгийн орлогыг

төвлөрүүлсэн байна. Цаашид цахилгаан хэмжлийн шалгалт баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Масс, цахилгаан, эзлэхүүн зарцуулалт, даралтын хэмжлийн лабораторийн шалгалт баталгаажуулалт болон шалгалт тохируулгын бүртгэл, протокол хөтөлсөн байна.

Ажлын эталон хэмжих хэрэгслийн техник ашиглалтын паспортыг бүрэн хөтөлсөн байна.

Масс болон эзлэхүүний хэмжлийн шалгалт тохируулгын аргачлал боловсруулан батлуулах, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын гэрчилгээг цахимаар хэлбэрээр хадгалж ажиллахыг зөвлөж байна.

2023 онд хэмжих хэрэгслийн улсын тооллогыг Сүхбаатар аймгийн 13 суманд хэмжүүр, хэмжих хэрэгсэл ашиглагч аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулан 5 хэмжлийн төрлөөр хийж (цахилгаан-11577ш, масс-488ш, эзлэхүүн зарцуулалт-3335ш, даралт-148ш, шалгалт тохируулга-25ш) нийт 15568 ширхэг хэмжих хэрэгслийн судалгааг гаргасан байна.

Цаашид урт, физик-хими, дулаан, температурын хэмжлийн төрлөөр судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийж ажиллах нь зүйтэй.

Хэмжил зүйн бодлогын газарт шаардлагатай ажлын эталон тоног төхөөрөмжийн судалгаа болон баталгаажуулсан хэмжих хэрэгслийн судалгааг сар бүр гаргаж хүргүүлсэн байна. Мөн даралтын ажлын эталон тоног төхөөрөмжийг шинээр бий болгосон байна.

3.3 Хэмжил зүйн хяналт шалгалтын чиглэлээр:

Хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн сул орон тоог нөхөх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

2024 оны эхний хагас жилийн байдлаар хийгдсэн ажил байхгүй

3.4 Сорьцын хяналтын чиглэлээр:

Сорьцын хяналтын чиглэлээр үнэт металлын эдлэл хийдэг үйлдвэр, худалдан борлуулдаг 4 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргасан байна.

Санхүүгийн зохицуулах хороо, Стандарт, хэмжил зүйн газраас зохион байгуулсан сургалтад үнэт эдлэлийн худалдаа эрхлэгч 3 иргэн, 1 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан байна.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 12/11 дугаар удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 5 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад сорьцын хяналт шалгалтыг хийсэн. Мөн 5 төрлийн 20 ширхэг гарын авлагыг олгосон байна.

Цаашид аж ахуйн нэгж, иргэдийн үнэт эдлэл худалдан борлуулж буй дэлгүүр, лангуунд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, иргэдэд үнэт металл, эрдэнийн чулуу, түүгээр хийсэн эдлэлийн сорьцын баталгааны талаар мэдээ мэдээлэл, зөвлөмж өгөх, сургалт сурталчилгаа хийх ажлыг сайжруулах, сорьцын хяналтыг хэрэгжүүлэх нь шаардлагатай байна.

3.5 Сорилтын лабораторийн үйл ажиллагааны чиглэлээр:

MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторид тавих ерөнхий шаардлага" стандартаар Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн TL-06-13 дугаар тушаалаар 4 жилийн хугацаатайгаар 74 нэр

төрлийн бүтээгдэхүүнд 459 үзүүлэлтээр хими, хор судлал, микробиологи, таримал ургамал, үр хорио цээрийн шинжилгээ хийхээр давтан итгэмжлэгдсэн байна.

Тус хэлтэс менежментийн тогтолцооны 24 журам, 194 стандарт, 13 шинжилгээний стандарт ажлын зааврыг үйл ажиллагаандаа ашиглан сорилт, шинжилгээг хийж байна.

Лабораторийн эрхлэгчээр Н.Цолмонтуяа, шинжээчээр Б.Эрдэмбилэг, Б.Мөнхцэцэг, Б.Мөнхцэцэг, лаборантаар Г.Саруулцэцэг, нийт 5 хүний орон тоотойгоор ажиллаж байна.

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар лабораторид шинжлэгдсэн сорьцын мэдээлэл:

- Хими, хор судлалын лаборатори: 167 сорьцод 695 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн ба стандартын шаардлага хангаагүй эерэг сорьцын тоо-46, үзүүлэлт-649 байна;
- Микробиологийн лаборатори: 133 сорьцод 254 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн ба эерэг сорьц: тоо-11, үзүүлэлт-243 байна;
- Таримал ургамал, үр хорио цээрийн лаборатори: 2 сорьцод 2 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 302 сорьцод 951 үзүүлэлтээр шинжилгээ хийж 2,500,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн ба LIMS (Лабораторийн мэдээллийн менежментийн тогтолцоо) программыг ашиглан албан хаагчид нь өөрийн нэр, нууц үгээр нэвтэрч лабораторид дээжийг хүлээн авч бүртгэх, сорилт шинжилгээний үр дүнг боловсруулах, дүнгийн хуудсанд бичих, тайлагнах, баталгаажуулах ажлыг гүйцэтгэж байна.

Хүсэлт, гэрээ, тендерт дүн шинжилгээ хийх журамтай. Уг журмын хүрээнд:

2024 онд 4 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулан гэрээг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шаардлага хангаагүй дээжийн бүртгэл, стандартын шаардлага хангаагүй дээжийг чиглэлийн улсын байцаагчид мэдэгдсэн бүртгэл, давтан стандартын шаардлага хангаагүй дээжийн судалгаа зэргийг баримтжуулах нь зүйтэй.

Үр дүнгийн чанар хангалт:

Лаборатори хоорондын харьцуулалт:

2023 онд Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтэстэй лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг хийсэн байна. Үүнд:

- Хими хор судлал: 2 лаборатори 1 дээжид 5 үзүүлэлт;
- Микробиологи: 2 лаборатори 1 дээжид 2 үзүүлэлт;
- Таримал ургамал, үр хорио цээр: 2 лаборатори 1 дээжид 1 үзүүлэлтээр харьцуулалтын шинжилгээг хийж үр дүнг тооцсон байна.

2024 онд лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг хийгүй байна. Иймд хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж батлуулах, эрчимжүүлэх шаардлагатай.

Ур чадварын сорилт:

2024 онд ХАБҮЛЛ-аас зохион байгуулсан ур чадварын сорилтын хөтөлбөрийн хүрээнд дараах чиглэлээр оролцож ажилласан байна. Үүнд:

- Хими хор судлал: 1 матрицад 1 үзүүлэлт;
- Таримал ургамал, үр хорио цээр: 1 матрицад 2 үзүүлэлтээр тус тус амжилтай оролцсон байна. Харин Нян судлал: оролцоогүй байна.

Аргын аргын баталгаажуулалт:

2023 онд Хими хор судлалын лаборатори хийсэн байна. 2024 оны хөтөлбөр, төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хангах, баримтжуулахад анхаарч ажиллах нь зүйтэй.

Дотоод хяналт:

2023 онд хими хор судлалын лаборатори дотоод хяналт хийсэн байна. Харин 2024 онд дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ ажлыг эрчимжүүлэх шаардлагатай.

Сорилтын лаборатори нь үр дүндээ хэмжлийн эргэлзээ тооцож ажиллаагүй байна.

Дотоод аудит:

2023 онд лабораторийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж удирдлагын дүн шинжилгээ хийсэн байна.

2024 онд лабораторийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж батлах, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Цаашид сорилтын лабораторийн албан хаагчдыг MNS ISO/IEC 17043:2010, MNS ISO 9001:2016 стандартын болон даралтад савны сургалт, хэмжлийн эргэлзээ тооцох арга зүйн чиглэлийн сургалтад хамрагдах, үр дүнгийн чанар хангалтыг сайжруулах, хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангаж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй.

Хэмжил зүйн нэгж дамжуулалт:

Сорилтын лабораторийн шинжилгээнд ашиглаж байгаа нийт 63 хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүртгэлтэй. Үүнээс шалгалт тохируулга хамруулбал зохих 21 ажлын хэмжих хэрэгслээс 14 ажлын хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулан нэгж дамжуулалтыг хангасан ба техник ашиглалтын паспорт хөтөлсөн байна. Үүнд:

- 2022 онд 3 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан;
- 2023 онд 8 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан;
- 2024 онд 3 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалтад хамруулсан.

Цаашид нэгж дамжуулалтыг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Шаардлагатай тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн судалгааг гаргаж аймгийн Засаг даргын тамгын газар болон Стандарт, хэмжил зүйн газрын Хэмжил зүйн бодлогын газарт хүргүүлсэн байна.

2023 онд (автоклав, термостат, рН метр)-ийг худалдан авсан байна.

Химийн бодис, урвалж:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 110 нэр төрлийн химийн бодис дээр 5 жилийн хугацаатайгаар олгосон байна.

Химийн хортой бодис болон аюултай хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлыг тээвэрлэх, устгах гэрээг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж ажиллах шаардлагатай байна.

2024 онд химийн бодис урвалжийн зардалд 15,6 сая төгрөгийн төсөв тавигдсан байна. Эхний ээлжийн химийн бодис, урвалжийг Цэцүүх трейд ХХК, Грийнхимистри ХХК, Монбиофарм ХХК -аас авсан байна. Гэрээг сунгуулах шаардлагатай.

Химийн бодис, урвалжийн зарцуулалтын тайланг хагас жил тутам тайлагнасан байна. Цаашид лабораторийн эрхлэгч, нягтлан хяналт тавин ажиллах шаардлагатай.

Загвар дээж устгалыг журмын дагуу устгаж, баримтжуулах, дээжийг кодолж хадгалах, холбогдох албан хаагчийг даралтад савны сургалтад хамруулах нь зүйтэй.

Химийн бодис урвалжийн хор аюулын зэрэглэл тус бүрээр гаргаж хавтасласан боловч ил тод байршуулаагүй байна.

Химийн бодис, урвалжийн хадгалах шүүгээ болон бодис, урвалж тус бүрд тэмдэг, тэмдэглэгээг хор аюулын зэрэглэлийг бүрэн гүйцээж байршуулах шаардлагатай байна.

Химийн бодис урвалж, стандартчилсан уусмалын хадгалалт, хамгаалалт, чанарт дотоод хяналт тавих ажлыг сайжруулах, ашиглалтын хугацаа хэтэрсэн бодис урвалж, стандартчилсан загвар уусмалд дотоод хяналт хийж, судалгааг гарган эрх бүхий байгууллагад өгч устгуулах шаардлагатай байна.

Лабораторийн ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд шийдвэрлэвэл зохих дараах асуудлуудтай байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн газрын байранд үйл ажиллагаа явуулдаг;
- Нян судлалын лабораторийн агааржуулалтын систем;
- Хими, хор судлалын лабораторийн агааржуулалтын систем;
- Химийн бодис хадгалах зориулалтын шүүгээгүй, бодисын ууршилттай.

Уг газарт галын дүгнэлт олгосон эсэх талаар тодруулах, шаардлагатай үед холбоо барих утасны жагсаалтыг ил тод байршуулах нь зүйтэй.

Цаашид химийн бодистой ажиллаж буй албан хаагч болон эзлэхүүн зарцуулалтын улсын шалгагч нарыг "Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын газар"-т эрүүл мэндийн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулах боломжийг судлах нь зүйтэй.

ДӨРӨВ. ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТ, ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨВЛӨРҮҮЛЭЛТ, ГЭРЧИЛГЭЭ ТООЦООТ БАРИМТ БИЧГИЙН АШИГЛАЛТ, ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛД ХЯНАЛТ ХИЙХ, САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ ХЭРХЭН ХАНГАГДАЖ БҮЙД ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ;

Тус хэлтэс нь 2024 онд үндсэн үйл ажиллагааныхаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан улсын төсвөөс 493,283,100 төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 47,800,000 төгрөг буюу нийт 541,083,100 төгрөгийн төсөв батлагдсан.

2024 оны эхний 05 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70407-СТАНДАРТЧИЛАЛ				
80101 - ҮНДСЭН ҮЙЛ				
120004 Төсөвт байгууллагын	18,800,000.00	45,831,550.00	(27,031,550.00)	243.8
122005 Төсвөөс санхүүжих	182,138,700.00	182,138,700.00	.	100.0
70407-СТАНДАРТЧИЛАЛ				
80101 - ҮНДСЭН ҮЙЛ				
АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	247,116,400.00	161,289,432.35	85,826,967.65	65.3
2101 Цалин хөлс болон	140,061,800.00	129,154,629.02	10,907,170.98	92.2
210101 Үндсэн цалин	91,512,400.00	88,171,289.63	3,341,110.37	96.3
210102 Нэмэгдэл	40,744,400.00	32,297,371.29	8,447,028.71	79.3
210103 Унаа хоолны	7,805,000.00	7,807,468.10	(2,468.10)	100.0
210104 Урамшуулал	—	878,500.00	(878,500.00)	0.0
2102 Ажил олгогчоос	17,550,200.00	8,863,293.64	8,686,906.36	50.5
210201 Тэтгэврийн даатгал	12,627,900.00	6,027,039.67	6,600,860.33	47.7

210202	Тэтгэмжийн даатгал	1,230,500.00	709,063.49	521,436.51	57.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	615,000.00	354,531.75	260,468.25	57.6
210204	Ажилгүйдлийн даатгал	615,500.00	354,531.75	260,968.25	57.6
210205	Эрүүл мэндийн	2,461,300.00	1,418,126.98	1,043,173.02	57.6
2103	Байр ашиглалттай	9,167,000.00	7,392,497.73	1,774,502.27	80.6
210301	Гэрэл, цахилгаан	833,500.00	465,677.73	367,822.27	55.9
210302	Түлш, халаалт	7,500,000.00	6,529,160.00	970,840.00	87.1
210303	Цэвэр, бохир ус	833,500.00	397,660.00	435,840.00	7.7
2104	Хангамж, бараа	8,550,000.00	4,841,311.96	3,708,688.04	56.6
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	123,750.00	1,076,250.00	10.3
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	2,500,000.00	.	100.0
210403	Шуудан, холбоо,	1,250,000.00	1,230,796.96	19,203.04	98.5
210405	Хог хаягдал зайлуулах.	100,000.00	90,000.00	10,000.00	90.0
210406	Бага үнэтэй, түргэн	3,500,000.00	896,765.00	2,603,235.00	25.6
2105	Нормативт зардал	7,479,000.00	3,826,200.00	3,652,800.00	51.2
210501	Эм, бэлдмэл,	6,516,500.00	3,588,300.00	2,928,200.00	55.1
210502	Хоол, хүнс	962,500.00	237,900.00	724,600.00	24.7
210503	Нормын хувцас зөөлөн	-	**		
2106	Эд хогшил, урсгал	8,333,500.00	1,980,000.00	6,353,500.00	23.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,250,000.00	1,980,000.00	4,270,000.00	31.7
210603	Хөдөлмөр хамгааллын	600,000.00	—	600,000.00	0.0
210604	Урсгал засвар	2,083,500.00	—	2,083,500.00	0.0
2107	Томилолт, зочны	6,666,500.00	5,011,500.00	1,655,000.00	75.2
210702	Дотоод албан	6,666,500.00	5,011,500.00	1,655,000.00	75.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн				
210801	Бусад нийтлэг				
2108	Бусдаар	1,230,700.00		1,230,700.00	0.0
210803	Даатгалын Үйлчилгээ	229,200.00		229,200.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн	209,100.00		209,100.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн	45,300.00		45,300.00	0.0
210806	Мэдээлэл технологийн	500,000.00		500,000.00	0.0
210807	Газрын төлбөр	127,500.00		127,500.00	0.0
210808	Банк санхүүгийн	19,600.00		19,600.00	0.0
210809	Улсын мэдээллийн	100,000.00		100,000.00	0.0
2109 Бараа үйлчилгээний		1,300,000.00	220,000.00	1,080,000.00	16.9
210901	Бараа үйлчилгээний	1,000,000.00	120,000.00	880,000.00	12.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн	300,000.00	100,000.00	200,000.00	33.3
80224 -ЗӨВЛӨЛ ХОРОО КОМИССЫН ГИШҮҮД					
122005	Төсвөөс санхүүжих	200,000.00	200,000.00	**	100.0
210801	Бусад нийтлэг	200,000.00	**	200,000.00	0.0
80227 - ЛАБОРАТОРИЙН ИТГЭМЖЛЭЛ					
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,800,000.00	2,800,000.00		100.0
122005	Төсвөөс санхүүжих	682,500.00	682,500.00	.	100.0
210801	Бусад нийтлэг	3,482,500.00		3,482,500.00	0.0
80802 - АЖИЛ ОЛГОГЧООС ОЛГОХ ТЭТГЭМЖ					
2132	Бусад урсгал	43,095,200.00	42,464,018.00	631,182.00	98.5
122005	Төсвөөс санхүүжих	43,095,200.00	43,095,200.00	**	
213207	Тэтгэвэрт гарахад олгох	42,695,200.00	42,064,018.00	631,182.00	98.5

21320	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00		100.0
	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН	247,716,400.00	274,747,950.00	(27,031,550.00)	110.9
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	247,716,400.00	203,753,450.35	43,962,949.65	82.3
	Мөнгөн хөрөнгийн 2024 оны 02		70,994,499.65		
	Үүнээс: банкны харилцах		70,994,499.65		

05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 247,716,400 төгрөгийн санхүүжилт авч үүнээс 203,753,450 төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа захиран зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 70,994,499 төгрөг байгаа нь 2024 оны 02 дугаар улирлын орлогын төлөвлөгөөний давуулан биелэлттэй холбоотой байна.

Орлогын гүйцэтгэл, төвлөрүүлэлтийн талаар:

2024 онд нийт 47,800,000 төгрөгийн орлого төлөвлөгдсөнөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 45,831,550 төгрөгийн орлого төвлөрч, үндсэн үйл ажиллагаанд санхүүжсэн. Бүтэн жилтэй харьцуулахад орлогын төлөвлөгөө 95.8%-ийн биелэлттэй байна.

Тус орлогын биелэлт нь тарифын үнийн өсөлт болон баталгаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Цаашид орлогын төлөвлөлтийг үнэн бодитой хийж төсөвт тусгуулах шаардлагатай.

Санхүүгийн аудитын дүгнэлтийн талаар:

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.6, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, түүвэр аудитад хамрагдсан. Тус аудитаар албан ажлын автомашинд GPS суурилуулахтай холбоотой 1 зөвлөмж, өгсөн. Зөрчил, акт, албан шаардлага, дүгнэлт гараагүй байна.

Шилэн дансны талаар:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөв захирагч нийт 171 мэдээ оруулахаас 69 мэдээ оруулж, 102 мэдээ нь оруулах хуулийн хугацаа болоогүй тул оруулаагүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 267,742,700 төгрөгийн 8 мэдээлэл байршуулахаас 214,406,600 төгрөгийн 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өглөг, авлагын талаар:

Байгууллагын хэмжээнд нийт 8,682,700 төгрөгийн өглөг үүссэн. Үүнд: Ажил мэргэжлийн код өөрчлөгдсөнтэй ажил олгогчтой холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 7,252,700 төгрөгийн өглөг үүссэнийг 6 дугаар сард залруулга хийж төлж барагдуулах зардал байна.

№	Нэр төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Тайлбар тодруулга
1	Өглөг	0.00	1430.00	0.00	1430.00	Сум болон УБ томилот

2	Өглөг	4804.50	2448.20	0.00	7252.70	Ажил мэргэжлийн код өөрчлөгдсөнтэй холбоотой тооцоолол хийх шаардлагатай
Нийт		4804.50	3878.20	0.00	8682.70	

Мөн дотоод албан томилолтын зардал нь батлагдсан төсвийн хуваарьт тавигдсан зардал нь бодит үүссэн зардлаас бага тавигдсан нь цаашид өр үүсэх эрсдэлтэй, хагас жилээр 1,430,000 төгрөгийн өглөг үүсэж байгаа тул төсвийн зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулах, төсвийн хуваарь өөрчлөлт оруулах саналаа илгээх нь зүйтэй.

Гэрчилгээ, тооцоот бичиг баримтын ашиглалт, зарцуулалтын талаар:

Тус хэлтэс нь нийт 10 төрлийн үнэт цаас бүхий тооцоот бичиг баримтыг ашиглаж байна. Үнэт цаасны зарцуулалтыг тулгаж, агуулахын үлдэгдлийг нь тоолж үзэхэд зөрүүтэй мэдээлэл гараагүй. Дараах анхаарах шаардлагатай зүйлс байна. Үүнд:

1. Гэрчилгээг шаардах хуудсаар мэргэжилтэнд олгох
2. Олгосон гэрчилгээнд мэргэжилтэнтэй сар бүр тооцоо нийлж баталгаажуулах,
3. Хүчингүй болсон гэрчилгээ, тооцоот баримтад бүртгэл жагсаалтыг гэрчилгээ тус бүрээр хөтлөх шаардлагатай.

№	Гэрчилгээ, тооцоот баримтын төрөл	2024.03.31-ны үлдэгдэл		Зарцуулсан		2024.06.10-ны Нийт үлдэгдэл		Орлогын дүн 2024.05.31
		Дугаар	Тоо	Дугаар	Тоо	Дугаар	Тоо	
1	Цахилгаан хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ	440001-441000	1000			440001-1000	1000	891,700
		214177-214250	74	214177-221	45	214222-250	29	
		266501-267100	600			266501-7100	600	
		341101-342100	1000			341101-2100	1000	
2	Дулаан даралтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ	011555-011560	6	011555-560	6			245,800
		27081-27280	200	27081-27174	94	27175-27280	106	
3	Бэлэн мөнгө хураах тасалбар	8997-9000	4	8997-9000	4			
		9062-9100	39	9062-9100	39			
		9103-9150	48	9103-9150	48			
		18642-18660	19			18642-18660	19	
		18673-18700	28			18673-18700	28	
		18951-19450	500	19001-19020	20	18951-19000	50	
						19021-19450	430	

4	Тохирлын гэрчилгээ/Монгол/	018067- 018076	20			018067- 018076	20	
		28413- 28420	16	28413	2			
				28414	2			
				28415- 28417	6			
				28418	2			
				28419- 28420	4			
		14-0001- 14-0050	100	140001- 0005	10			
				14-0006	2			
				140007- 0050	88			34,696,900
		14-051- 14-0150	200	140051- 0057	14			
				14-0058	2			
		140059- 0072	28	1400073- 0150	156			
5	Тохирлын гэрчилгээ/Англи/	14-0201- 0250	100			140201- 0250	100	
		14-0251-- 0400	300			14-0251- 0400	300	1,165,200
		14-0126- 0200	150	140126- 0166	82	14-0186- 0200	30	
6				14-0167- 0171	10			
				14-0172- 0185	28			
7	Механик хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ	60851- 61050	200			60851- 61050	200	6,468,950
		39045- 39350	306	39045- 39321	277	39322- 39350	29	
8	Эзлэхүүн зарцуулалтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээ	101585- 101684	100	101585- 1660	76	101661- 1684	24	2,688,000
		98858- 98874	17	98858- 98874	17			
9	Шалгалт тохируулга	33375- 33422	48	33375- 33392	18	33393- 33422	30	657,000
		28881- 28905	25			28881- 28905	25	
10	Усны гэрчилгээ	33688- 34500	813	33688- 33727	40	33728- 34500	773	1,818,000
11	Салбар сан							642,200
12	Лаборатори							2,979,850
Дүн		0	5913	85245	964	0	4949	48,631,550

ТАВ. СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН АЛБАН ХААГЧДАД ТАВИХ ШААРДЛАГА CS11-0182:2022 БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ;

Стандарт, хэмжил зүйн салбарын хэмжээнд байгууллагын үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг салбарын хэмжээнд төлөвшүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/82 дугаар тушаалаар Стандарт, хэмжил зүйн салбарын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавих шаардлага CS11-0182 стандартыг шинэчлэн баталж, салбарын хэмжээнд мөрдөн ажиллаж байна.

Тус хэлтэс нь байгууллагын стандартын дагуу доорх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

1. Ажилтан, албан хаагчдад байгууллагын стандартаар сургалтыг зохион байгуулсан.
2. Байгууллагын гаднах хаяг, логог шинэчилсэн,
3. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан мэдээллийн самбарыг байршуулсан,
4. Байгууллагын танилцуулга, гарын авлага, тараах материалыг байршуулсан,
5. Албан хаагчид ажлын байранд болон албан томилолтоор албан үүргээ гүйцэтгэхдээ өмсдөг ажлын хувцастай, үнэмлэхтэй,
6. Байгууллагын үйл ажиллагаанд бэлэг тэмдэг (лого)-ийг ашигласан. Төрийн болон байгууллагын далбааг залсан байна.
7. Өрөөний хаягийг Монгол бичиг, кирилл үсгээр хослуулан бичиж байрлуулсан,
8. Байгууллагын дотоод тохижилт, эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээ нь салбарын үйл ажиллагаа болон албан хаагчдад тавих шаардлагыг ханган ажиллаж байна.

ЗУРГАА. АРХИВ, АЛБАН ХЭРГИЙН ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ, БҮРТГЭГДСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ТҮҮНИЙ БАРАГДУУЛАЛТ;

Архив, албан хэрэг хөтлөлт, бүрдэлт:

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны тоон мэдээллийг харуулбал:

- А тушаал 6 (Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр);
- Б тушаал 5 (Хүний нөөцийн чиглэлээр);
- Ирсэн бичиг 80 (Хариутай бичиг- 25), (Хугацаа болоогүй 2);
- Явуулсан 27;
- Өргөдөл, гомдол, хүсэлт 47 (шийдвэрлээгүй 4).

Ирсэн, явсан бичгийг бүртгэсэн ба бичиг хэргийн эмх цэгц, дэс дараалал сайн, тушаалын шийдвэрийн төсөлд санал авах хуудсыг хавсаргасан байна. Харин тушаалын бүртгэлийн дэвтэргүй, бүртгэлгүй, төсөл боловсруулсан, хянасан гарын үсгийн баталгаажуулалт байхгүй, тушаал болон албан бичгийг цахим хэлбэрээр хадгалаагүй, гэрээнд нэгдсэн байдлаар дугаар олголт хийгдээгүй байна.

Архивын зориулалтын өрөөтэй. 2023 оны 47 нэр төрлийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталсан байна. Баримт материалуудыг архивласан ч зарим нэг баримт материалын дотоод товьёг, баталгааны маягт хийгдээгүй, гарын үсгийн бүрдэл дутуу байна. Архивын нэгжийн баримт материалыг хүлээлцсэн бүртгэл хөтлөх шаардлагатай.

Төрийн архивд 2023 онд 2009-2014 оны байнга хадгалах баримт бичиг, хөмрөгийн хэрэг зэргийг хүлээлгэн өгсөн байна.

Цаашид Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 246 тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дугаар А/222 тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг дагаж мөрдөн холбогдох бүрдэл, шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна.

ДОЛОО. ИЛ ТОД БАЙДАЛ, НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХИЙСЭН БАЙДАЛД ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ;

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн үйл ажиллагааны ил тод байдлыг Баянхонгор аймаг дахь СХЗХ нь цахим хуудас, фэйсбүүк хаяг, байгууллагын мэдээллийн самбараар мэдээлэл түгээн ажилласан байна.

1. Masm.gov.mn цахим хуудсанд 33 мэдээлэл,
2. Facebook-ийн Сүхбаатар пейж хуудсанд 400 мэдээ, мэдээлэл оруулсан,
3. Мэдээллийн самбарт:
 - ✓ Эрхэм зорилго
 - ✓ Албан хаагчдын танилцуулга
 - ✓ Холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмууд
 - ✓ Мэдээ, мэдээлэл (Санхүүгийн мэдээлэл, дотоод сургалтын төлөвлөгөө, Албан хаагчдын утасны дугаар, шинээр батлагдсан стандартын жагсаалт гэх мэт)
4. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн хүснэгтийн 1.4, 1.5, 1.9, 5.4, дахь заалтуудыг masm.gov.mn сайтад нөхөж мэдээлэх шаардлагатай. masm.gov.mn сайтаас шилэн дансанд орох холбоос нь алдаа заасан нэвтрэх боломжгүй байна.

НАЙМ. ӨМНӨХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНЭЭС ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГӨХ;

Стандарт, хэмжил зүйн газраас 2022 оны 04 дүгээр сард хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 22 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

№	Зөвлөмжийн дугаар	Зөвлөмж
1.	2	Нэгжийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналт, үнэлгээнд анхаарах, албан хаагчдын ажлын бүтээмж, цаг ашиглалтад хяналт тавих;
2.	6	Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар MNS ISO/IEC 17067 стандарт, агентлагийн даргын 2018 оны А/254 дүгээр тушаалаар батлагдсан Монгол улсад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журамд заагдсан үйл явцыг бүрэн хэрэгжүүлэх;
3.	7	Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17065 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэх, байнгын сайжруулалт хийх;
4.	11	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтний Албан тушаалын тодорхойлолтын гүйцэтгэх чиг үүргийн (2 дугаар зорилтын 7 дугаар заалт) хүрээнд Сүхбаатар аймгийн хэмжээнд хэмжил зүйн хяналт шалгалтад заавал хамрагдах болон шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн нарийвчилсан судалгааг гаргах, дүн шинжилгээ хийх;
5.	20	Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэх, байнгын сайжруулалтыг хийх, Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандартын сургалтад хамрагдах, хэлтэс дотроо

	сургалт зохион байгуулах, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээг үр дүнтэй хэрэгжүүлэх, илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээг авах;
--	---

Дараагийн газар дээрх хяналт-шинжилгээгээр дээрх зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй албан хаагчдад хариуцлага тооцох үндэслэл болохыг анхааруулж байна.

Хяналт-шинжилгээний явцад 5 албан хаагчийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийсэн бөгөөд зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хэмжих боломжгүй, томъёолол нь буруу, хүрэх түвшин нь шалгуур үзүүлэлттэйгээ нийцэхгүй байна. Иймд хаалтын хуралд зарим шалгуур үзүүлэлтийг тайлбарлан зөвлөмжилсөн ба хэлтсийн нийт албан хаагчдыг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан журам, аргачлалыг уншиж, судлан хэлтэс дотроо хэлэлцэж, ойлголтын зөрүүгээ арилгах чиглэл өгсөн.

Түүнчлэн журмын дагуу хэлтсийн дарга нь албан хаагчидтай явцын ярилцлага хийх, хамт олны үнэлгээг хийх шаардлагатай.

ЕС. СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР БОЛОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРААС ӨГСӨН ШУУРХАЙ ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ ӨГӨХ;

Үүрэг даалгаврын хэрэгжилтийг ирсэн бичгийн бүртгэлийн дэвтрээс шүүлт хийн үзлээ.

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Стандарт, хэмжил зүйн газраас хурал зөвлөгөөнд оролцуулах, дүрэм журмын төсөлд санал авах, сургалтад оролцуулах, тайлан мэдээлэл авах чиглэлээр 33, Сүхбаатар аймгийн засаг даргын Тамгын газраас болон бусад төрийн байгууллагаас хурал зөвлөгөөнд оролцуулах, сургалт, тэмцээн уралдаанд оролцуулах, судалгаа, санал авах, тайлан мэдээлэл авах чиглэлээр 23 үүрэг даалгавар өгөгдсөн байна.

Хэрэгжилтийг явсан бичгийн бүртгэлийн дэвтрээс хянан үзэхэд албан бичиг болон сургалтад хамрагдах, төсөлд санал өгөх, судалгаа мэдээлэл гаргаж өгөх, хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаанд оролцох, тайлан мэдээлэл хүргүүлэх байдлаар хаасан ч холбогдох газарт хүргүүлсэн албан тоот болон баримт бичиг, материал байхгүй байна. Цаашид албан бичгээр хүргүүлэх, холбогдох материалыг баримтжуулахад анхаарч ажиллах нь зүйтэй.

ДҮГНЭЛТ:

Сүхбаатар аймаг дахь СХЗХ нь төрийн үйлчилгээний 2 дугаар байрны 11 давхарт, Сорилтын лаборатори нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 31 дүгээр хуралдааны тэмдэглэлд зөвшөөрснөөр Улсын бүртгэлийн хэлтсийн (Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 109 дүгээр тогтоолоор татан буугдсан Мэргэжлийн хяналтын газраас шилжсэн) байранд 2 тусдаа байрлалд үйл ажиллагаа явуулж байна.

Тус хэлтэс нь төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж HS710 маркийн манометр шалгах эталон тоног төхөөрөмжтэй болсноор хэмжих хэрэгслийн нэр төрлийг 2024 онд нэгээр нэмэгдүүлжээ.

2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 14 ширхэг ажлын эталоныг нэгж дамжуулалт, шалгалт тохируулгад хамруулан үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд 22 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, 1138 хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт, 302 сорьцод 951 үзүүлэлтээр шинжилгээ хийж, 116 үйлчилгээнд баталгаажуулалт хийн тохирлын гэрчилгээ олгож, 37 стандарт борлуулсан байна.

Байгууллагын стандартад зөвлөгөө өгөх ажлыг эрчимжүүлэн (Нурууны бүс ТШ CS 11-0564:2024, Арьсан цүнх ТШ CS11-0563:2024, Өргөлийн уут ТШ CS 11-0565:2024) 3 стандартад зөвлөгөө өгч Стандарт, хэмжил зүйн газарт бүртгүүлсэн нь сайшаалтай байна.

2024 онд нийт 47,800,000 төгрөгийн орлого төлөвлөгдсөнөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 45,831,550 төгрөгийн орлого төвлөрч, үндсэн үйл ажиллагаанд санхүүжсэн. Бүтэн жилтэй харьцуулахад орлогын төлөвлөгөө 95.8%-ийн биелэлттэй байна.

Мөн дотоод албан томилолтын зардал нь батлагдсан төсвийн хуваарьт тавигдсан зардал нь бодит үүссэн зардлаас бага тавигдсан нь цаашид өр үүсэх эрсдэлтэй, хагас жилээр 1,430,000 төгрөгийн өглөг үүсэж байгаа тул төсвийн зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулах, төсвийн хуваарь өөрчлөлт оруулах саналаа илгээх нь зүйтэй.

Лабораторийн шинжилгээг Монгол Улсын Шадар Сайдын 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар тушаалаар баталсан журмын 6 дугаар зүйлд заасан тохиолдлуудад холбогдох газрын хяналт шалгалтын удирдамжийг үндэслэн төлбөрөөс чөлөөлөн үнэ төлбөргүй хийж байна.

Он	Нийт шинжилгээ		Төлбөртэй		Төлбөргүй	
	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
2023	654	6,813,800	648	5,131,400	6	1,682,400
2024.05.31	301	4,416,700	289	4,047,600	12	369,100

Санхүүгийн үйл ажиллагааны сахилга бат, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдэл, эмх цэгц сайн байна.

Цаашид хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжид дурдагдсан зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байх, зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ахиц өөрчлөлтийг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ:

1. Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хугацаандаа хэрэгжээгүй болон дутуу хэрэгжилттэй ажлыг эрчимжүүлэх, төлөвлөсөн хугацаанд биелэлтийг нь хангуулах, хяналт тавих;
2. Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналт, үнэлгээг холбогдох журмын дагуу сайжруулалт хийх;
3. Аливаа шийдвэр гаргахдаа эрх зүйн үндэслэлийг зөв тодорхойлох, хууль хэрэглээг зөв хэрэглэх;
4. Хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн сул орон тоог нөхөхөд санаачилгатай ажиллах, хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх;
5. Аж ахуйн нэгж, иргэдээс тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн хүсэлтэд дарга нь цохолт хийх, ирсэн бичгийн бүртгэлд бүртгэж хэвших;
6. Шударга байдлын хороо байгуулах;
7. Баталгаажуулалтын зөвлөлийн гишүүдийг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан шинэчлэх, баримтжуулах;
8. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийлгэхээр ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээ хийх үйл явцыг сайжруулах;
9. Сорилтын үр дүнг хүчин төгөлдөр норматив техникийн баримт бичгээр тогтоосон шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийх;
10. Хүсэлт гаргагчтай холбоо тогтоох(Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор хүсэлт гаргагчид тохирлын үнэлгээ явуулах эсэх талаар шийдвэрийг мэдэгдэх);

11. Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх тайланд асуудлыг бүрэн тусгах;
12. Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17065 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэх, итгэмжлэгдэх;
13. Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлагдсан "Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалтын хүрээнд Сүхбаатар аймгийн хэмжээнд хэмжил зүйн хяналт-шалгалтад хамрагдах хэмжих хэрэгслийн судалгааг хэмжлийн төрөл тус бүрээр гаргаж мэдээллийн сан бий болгох, төлөвлөлтөд ашиглах;
14. Хэмжил зүйн болон сорилтын лабораторийн ажлын эталон тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулан нэгж дамжуулалтад бүрэн хангах;
15. Цахилгаан хэмжлийн шалгалт баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх;
16. Масс болон эзлэхүүний шалгалт тохируулгын аргачлал боловсруулан батлуулах;
17. Шалгалт тохируулгад хамрагдсан хэмжих хэрэгслийн гэрчилгээг цахимаар хэлбэрээр хадгалах;
18. Сорилтын лабораторийн үр дүнгийн чанар хангалт (*лабораторийн хоорондын харьцуулалт, үр чадварын сорилт, аргын баталгаажуулалт, дотоод хяналт*)-ын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх;
19. Сорилтын лаборатори хэмжлийн эргэлзээг тооцож ажиллах;
20. Сорилтын лабораторийн албан хаагчдыг MNS ISO/IEC 17043:2010, MNS ISO 9001:2016 стандартын болон даралтад савны сургалт, хэмжлийн эргэлзээ тооцох арга зүйн чиглэлийн сургалтад хамрагдах;
21. ISO 9001, ISO/IEC 17065, ISO/IEC 17025 стандартын шаардлагын дагуу дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийх;
22. Химийн хортой бодис болон аюултай хог хаягдал, химийн бодисын сав баглаа боодлыг тээвэрлэх, устгах гэрээг байгуулах;
23. Химийн бодис, урвалжийн зарцуулалтын тайланд лабораторийн эрхлэгч, нягтлан хяналт тавин ажиллах;
24. Химийн бодис урвалжийн хадгалах шүүгээ болон бодис, урвалж тус бүрд тэмдэг, тэмдэглэгээг хор аюулын зэрэглэлээр байршуулах;
25. Химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийг гаргах, ил тод байлгах;
26. Химийн бодис урвалж, стандартчилсан уусмалын хадгалалт, хамгаалалт, чанарт дотоод хяналт тавих ажлыг сайжруулах, ашиглалтын хугацаа хэтэрсэн бодис урвалж, стандартчилсан загвар уусмалын судалгааг гаргаж, эрх бүхий байгууллагад өгч устгуулах;
27. Химийн бодистой ажиллаж буй албан хаагч болон эзлэхүүн зарцуулалтын улсын шалгагч нарыг "Мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын газар"-т эрүүл мэндийн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулах боломжийг судлах, хамруулах боломжийг судлах;
28. ISO 9001, ISO/IEC 17065, ISO/IEC 17025 стандартын шаардлагын дагуу дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ хийх;
29. Сорилтын лабораторийн албан хаагчдыг MNS ISO/IEC 17043, MNS ISO 9001 стандартын болон даралтад савны сургалт, хэмжлийн эргэлзээ тооцох арга зүйн чиглэлийн сургалтад хамруулах;
30. Орлогын төлөвлөлтийг үнэн бодитой хийж төсөвт тусгуулах;
31. Гэрчилгээг шаардах хуудсаар мэргэжилтэнд олгох, сар бүр тооцоо нийлж баталгаажуулах, хэвших;
32. Хүчингүй болсон гэрчилгээ, тооцоот баримтад бүртгэл жагсаалтыг гэрчилгээ тус бүрээр хөтлөх;
33. Лабораторийн үнэ төлбөргүй хийгдэж байгаа шинжилгээнүүдэд хяналт тавих, холбогдох газруудын удирдамжийг анхан шатны баримтын бүрдэлд хавсаргах;

34. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах хуулийн хугацааг анхаарч ажиллах;
35. Харилцахын зарлагын гүйлгээний баримтыг 1,2 дугаар гарын үсэг, хэлтсийн тамга, цахим төлбөрийн баримтаар баталгаажуулан архив үүсгэх;
36. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн хүснэгтийн 1.4, 1.5, 1.9, 5.4 дахь заалтуудыг mast.gov.mn сайтад нөхөж мэдээлэх;
37. Тушаалын бүртгэлийн дэвтэр хөтлөх, хувийн хэргийн бүрдлийг хангах;
38. Тушаал, ирсэн, явсан албан бичгийг цахим хэлбэрээр хадгалах;
39. Хэлтсээс аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулж буй гэрээг бүртгэх, нэгдсэн байдлаар дугаар олгох;
40. Хадгаламжийн нэгжийн баримт материалын дотоод товьёг, баталгааны маягтыг бүх баримтад хийх, гарын үсгийн бүрдлийг хангах;
41. Архивын нэгжийн баримт материалыг хүлээлцсэн бүртгэл хөтлөх;
42. Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дугаар 246 тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн дугаар А/222 тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ыг дагаж мөрдөн холбогдох бүрдэл, шаардлагыг хангаж ажиллах;
43. Албан хаагчдын ажлын бүтээмж, цаг ашиглалтад хяналт тавих, гадуур ажлын бүртгэл хөтлөх;
44. Зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 2024 оны 07 дугаар сарын 20-ний өдрийн дотор, хэрэгжилтийн тайланг журмын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх;

ТАЙЛАН БИЧСЭН:

АЖЛЫН ХЭСГИЙН
АХЛАГЧ:



Ч.ОТГОНЦЭЦЭГ


(Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга)

ГИШҮҮД:



Х.ОТГОНБАЗАРРАГЧАА

(Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын ахлах
мэргэжилтэн)



Ж.МӨНХБАЯР

(Хяналт-шинжилгээ,
үнэлгээ, дотоод аудитын
газрын мэргэжилтэн)

2024 оны 06 дугаар сарын 27